



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 5/34

Ховд

Албан үүргийг түр орлон  
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлагаар Төрийн албаны тухай хуулийн дагуу сул орон тоог сонгон шалгаруулалтаар нөхөх хүртэл хугацаанд Чойдогийн Нэргүйг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн аймгийн Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ч.Нэргүйд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”-ний ТЗ-4 дэх шатлалаар цалинжуулж, хууль тогтоомжид заасан холбогдох нэмэгдлүүдийг сар бүр бодож олгохыг Байгаль орчны газрын нягтлан бодогч (Г.Чанцалдулам)-д зөвшөөрсүгэй.

3. Ч.Нэргүйн ажлыг хүлээлцэж, холбогдох тооцоо хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрд тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Ч.Нэргүйд даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн Б/27 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8400001 Зах.Б/34 Ба

Засаг даргын 2024 оны  
11 дүгээр сарын 25-ны өдрийн  
Б/34 дүгээр захирамжийн хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Гомбосүрэн (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
- Гишүүд:
- З.Уянга (Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
  - Г.Чанцалдулам (Аймгийн Байгаль орчны газрын нягтлан бодогч)
  - Р.Энэбиш (Аймгийн Байгаль орчны газрын нярав)
- Нарийн бичгийн дарга: Э.Оюунтунгалаг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

-оОо-